



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 34

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгөд үнэлгээ
тогтоон худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвандөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу татан төвлөрүүлсэн Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12,930,683.44 /арван хоёр сая есөн зуун гучин мянга зургаан зуун наян гурав/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 37-26 ДУА улсын дугаартай УАЗ Патриот маркийн автомашиныг нэгдүгээр хавсралтаар Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд балансаас балансад шилжүүлэх, хоёрдугаар хавсралтад дурдсан Дэлгэрцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 27,225,000 /хорин долоон сая хоёр зуун хорин таван мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 14,179,687.50 /арван дөрвөн сая нэг зуун далан есөн мянга зургаан зуун наян найм/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 38-59 ДУА улсын дугаартай УАЗ-315195-066 маркийн автомашины худалдах доод үнийг 14,200,000 /арван дөрвөн сая хоёр зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.


2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Т.Батжаргал), Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.


ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 27 өдрийн
34 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



Сайнцагаан сумын ИТХурлаас Сайнцагаан сумын ЗДТГазарт шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
3	SUV	UAZ PATRIOT	ДУА	37-26	2015	2015.11.10	316300F 0525990	2693,В		12,930,683.44	12,930,683.44	0
Хөрөнгийн нийт дүн										12,930,683.44 /арван хоёр сая есөн зуун гучин мянга зургаан зуун наян гурван төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөг	12,930,683.44 /арван хоёр сая есөн зуун гучин мянга зургаан зуун наян гурван төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөг	



 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
 34 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн		Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сер и	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
3	SUV	UAZ-315195-066	ДУА	38-59	2014	2014.08.05	315100E0591087	2693,В	27,225,000	13,045,312.50	14,179,687.50	14,200,000
Хөрөнгийн нийт дүн									27,225,000 /хорин долоон сая хоёр зуун хорин таван мянга/ төгрөг	13,045,312.50 /арван гурван сая дөчин таван мянга гурван зуун арван хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөг	14,179,687.50 /арван дөрвөн сая нэг зуун далан есөн мянга зургаан зуун наян долоон төгрөг тавин мөнгө/ төгрөг	14,200,000 /арван дөрвөн сая хоёр зуун мянга/ төгрөг